



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32 01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.audit.mn


2016.03.04 № 286  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Ц.АЛТАНЦАЦРАЛ  
ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,  
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж  
байна.

Хавсралт 27 хуудас

ДЭД ДАРГА



Я.САМБУУНЯМ



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2016.02.04

№

285

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ**

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газраас аудит хийв.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн аудитын газар нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

1110400285

### Зөрчилгүй санал дүгнэлт

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ц.ОЧИРБАТ